



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/51

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.16 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн яам, Монголын Диабетийн холбоотой хамтран хэрэгжүүлэх “Чихрийн шижин ба чихрийн шижингийн ретинопатийн тусламж үйлчилгээний загвар”-ыг орон нутагт бий болгох төслийн ажлыг удирдан зохион байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Т.Дэлгэрсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд

Э.Батмөнх - Жаргалант сумын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан Засаг даргын орлогч

Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ц.Мягмарсүрэн - Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

П.Гэрэлсүрэн - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал

Б.Лусалмаа - Эрүүл мэндийн газрын мэдээлэл, сургалт сурталчилгааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Отгонбаяр - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотрын тасгийн их эмч

Э.Оюунгэрэл - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нүдний тасгийн их эмч


Нарийн бичгийн

дарга: С.Дорж

- Аймгийн Засаг даэргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

- 8400 01-0259

2. Төслийн хэрэгжилтийн явц, хэрэгжүүлж буй арга хэмжээний тогтвортой байдалд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, ажлын хэсгийн ахлагч (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ